



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2017


ИТХ-ын ажлын  
алба  
2017.12.11





# Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаа

Сумын ИТХ-ын хуралдаан 4 удаа хуралдаж 12 тогтоол батлан гаргав.



Сумын ИТХ-ын хуралдаан





# ИТХ-ын хуралдааны шийдвэр

№	Хуралдаан	Сар өдөр	Хэлэлцсэн асуудал,
1	Ээлжит 5 дугаар хуралдаан	I/20	<ol style="list-style-type: none"><li>1.Тооллогын комисс томилох тухай</li><li>2.Сумын Засаг даргад нэр дэвшүүлэх тухай</li><li>3. Төсвийн тодотгол</li><li>4.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулах тов зарлах тухай</li></ol>
2	Ээлжит 6 дугаар хуралдаан	VII/05	<ol style="list-style-type: none"><li>1.Сумын 2017 оны төсөвт тодотгол хийх тухай /Орон нутгийн төсөвт байгууллагын 2017 оны төсвийн тодотгол, Орон нутгийн хөгжлийн сан/</li><li>2.Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх, орлогыг нэмэгдүүлэх талаар зохиож буй ажил</li><li>3. Сум хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах</li><li>4.Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн дээд хэмжээг шинэчлэн тогтоох</li><li>5.Аавуудад зориулсан хүндэтгэлийн хөшөөг сумын хамгаалалтанд авах тухай</li></ol>
3	Ээлжит 7 дугаар хуралдаан	X/16	<ol style="list-style-type: none"><li>1. Төсвийн тодотгол</li><li>2. Хүрэн бухтын дөрөлжний дурсгалын хөшөөг сумын хамгаалалтанд авах тухай</li><li>3.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн “Нөхөн сэргээлт хийлгэх тухай” 2/09 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай</li><li>4.Тусгай зөвшөөрлийг цуцлуулах тухай</li></ol>
4	Ээлжит бус 8 дугаар хуралдаан	XII/02	Сумын 2017 оны төсөвт тодотгол хийх тухай



# Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид

1

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
Хуралдаан -11

2

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
тогтоол -30

3

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
тэмдэглэл -11



# Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан





# Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Бэлчээрийн эрсдлийн менежментийн төлөвлөгөө

Эрүүл мэндийн салбар зөвлөлийн төлөвлөгөө

Орон нутгийн хяналтын зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Усны үнэ тогтоох тухай

Гудамж, хорооллыг хаягжуулах тухай

Нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих тухай

**Зарим  
шийдвэрээс**



# Зохион байгуулсан арга хэмжээ

Сумын хөгжилд  
малчин  
эмэгтэйчүүдийн  
оролцоо

Гэр бүлийн  
хөгжил  
хамгаалалд  
хамтдаа

Чуулган

Сумын хөгжилд  
эрчүүд бидний  
оролцоо

Сумын хөгжилд  
хүүхдийн оролцоо



## “Сумын хөгжилд малчин эмэгтэйчүүдийн оролцоо” малчин эмэгтэйчүүдийн анхдугаар чуулган

“Сумын хөгжилд малчин эмэгтэйчүүдийн оролцоо” малчин эмэгтэйчүүдийн анхдугаар чуулганыг 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдөр сумын Соёлын төвд амжилттай зохион байгуулсан. Чуулганд 4 багийн 250 гаруй малчин эмэгтэйчүүд оролцож сум орныхоо хөгжил дэвшилд өөрсдийн оруулах хувь нэмэр, малчин эмэгтэйчүүдийн дунд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх зэрэг асуудлуудаар бүтэн өдрийн турш хамтдаа чуулсан.





# “Сумын хөгжилд малчин эмэгтэйчүүдийн оролцоо” малчин эмэгтэйчүүдийн анхдугаар чуулган

СУМЫН ХӨГЖИЛД МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО  
**МАЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН  
АНХДУГААР ЧУУЛГАН**  
ЖАРГАЛАНТ СУМ 2017





# “Сумын хөгжилд малчин эмэгтэйчүүдийн оролцоо” малчин эмэгтэйчүүдийн анхдугаар чуулган

## УРИАЛГА

Малчин эмэгтэйчүүдийн дунд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн идэвх санаачлагыг сайжруулах чиглэлээр доор дурдсан агуулга бүхий уриалгыг “Сумын хөгжилд малчин эмэгтэйчүүдийн оролцоо” чуулганд оролцогчдоос гаргаж байна.

1. Эмэгтэйчүүд өөрийгөө хөгжүүлэх арга ухаанд суралцаж, гэр бүл, нийгмийн сайн сайхны төлөө өөрчлөлтийг өөрөөсөө эхэлж, өөрсдөө чадавхжин хөгжих

2. Аливаа тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэхийн тулд шийдвэр гаргах түвшинд оролцоогоо нэмэгдүүлэх

3. Байгаль дэлхийгээ хайрлах, уламжлалт зан заншлыг түгээн дэлгэрүүлж, ногоон хөгжлийн төлөө бодит ажил өрнүүлэх

4. Орон нутгийн онцлог, бүс нутгийн чиглэлд тулгуурлан малын үүлдэр угсааг сайжруулах замаар нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, мал, сүү, ноос ноолуур зэрэг малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжийг судалж, хоршиж ажиллах

5. Малчин эмэгтэйчүүдийн дунд тулгамдсан асуудлыг тухай бүр тодорхойлж, энэ талаар төрөөс баримтлах бодлого шийдвэр, хууль тогтоомжид тусгуулах санал дэвшүүлэх

6. Мал аж ахуйн салбарт үр дүнтэй ажилласан эмэгтэйчүүдийн ажлын амжилт үр бүтээлийг үнэлүүлэхэд анхаарах

7. Малчин эмэгтэйчүүд бид эрүүл мэнд, нийгмийн даатгалдаа бүрэн хамрагдаж, нийгмийн баталгаагаа хангах

ЧУУЛГАНД ОРОЛЦОГЧИД

2017.03.07

Чуулганаас  
уриалга  
гаргасан.



# “Сумын хөгжилд -Эрчүүд бидний оролцоо” эрчүүдийн чуулган





## Сумын хөгжилд -Эрчүүд бидний оролцоо” эрчүүдийн чуулган

Сумын ИТХ, ЗДТГ, ГХУСАЗ салбар зөвлөл хамтран “Сумын хөгжилд-Эрчүүд бидний оролцоо” сэдэвт эрчүүдийн чуулганыг 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр сумын Соёлын төвд амжилттай зохион байгуулсан. Чуулганд 4 багийн 150 гаруй эрчүүд оролцов.



# “Сумын хөгжилд эрчүүд бидний оролцоо” эрчүүдийн чуулган

## УРИАЛГА

Эрчүүдийн нийгмийн идэвх санаачлагыг сайжруулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сумын хөгжлийн асуудалд тэдний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр доор дурдсан агуулга бүхий уриалгыг “Сумын хөгжилд эрчүүд бидний оролцоо” чуулганд оролцогчдоос гаргаж байна.

1. Өөрийгөө хөгжүүлэх арга ухаанд суралцаж, өөрсдөө чадавхин хөгжих
2. Орон нутагт тулгамдаж буй бэрхшээл болон хөгжлийн асуудалд гар бие оролцож, хувь нэмрээ оруулах
3. Гэр бүл, нийгмийн сайн сайхны төлөө өөрчлөлтийг өөрөөсөө эхэлж архи, тамхи зэрэг хорт зуршлаас татгалзах
4. Аз жаргалтай, амар тайван гэр бүлийн төлөө гэр бүлийн аз жаргал, үнэт зүйлийг эрхэмлэж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх
5. Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах уламжлалт заншлыг хэрэглэх, үр хүүхдээ байгальд ээлтэй иргэн болгон төлөвшүүлэх

ЧУУЛГАНД ОРОЛЦОГЧИД

2017.03.17

Чуулганаас  
уриалга  
гаргасан.



# “Сумын хөгжилд –Хүүхдийн оролцоо” хүүхдийн чуулган



2017.04.25





# “ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛАЛД ХАМТДАА” гэр бүлийн чуулган





## “ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛАЛД ХАМТДАА” гэр бүлийн чуулган

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтран 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдөр "Гэр бүлийн хөгжил хамгаалалд хамтдаа" сэдэвт гэр бүлийн чуулган зохион байгууллаа. Чуулганд 150 гаруй иргэд оролцож, чуулганыг сумын ИТХ-ын дарга Ж.Уранчимэг нээж, хөтөлбөрийн дагуу мэргэжилтэн, албан хаагчид мэдээлэл хийсний дараа Монгол Улсын гавьяат багш, сурган хүмүүжүүлэх ухааны доктор Шархүүгийн Чимгээ "Гэр бүлийн сайн сайхны төлөө" сэдэвт 2 цагийн сонирхолтой лекц уншиж, иргэдэд оюуны хөрөнгө оруулалт хийлээ. Гэр бүлийн чуулганаас 6 заалт бүхий уриалга гаргасан. Чуулганы төгсгөлд шилдэг гэр бүлүүдийг 9 номинацаар шалгаруулж, алдаршуулсан. Мөн албан байгууллагууд өгөгдсөн сэдвийн дагуу 10 минутын урьдчилж бэлтгэсэн “Дүрийн тоглолт”-ыг үзүүлж, хуулийг сурталчилсан. Үүнд:

- 1.ЗДТГ-Нэгдүгээрт хүүхэд
- 2.Байдраг ахлах сургууль-Гэр бүлийн хүчирхийлэл
- 3.Сум дундын эмнэлэг-Архи, тамхины хор уршиг
- 4.Цэцэрлэг-Гэр бүлийн хүмүүжил хүүхдийн хүмүүжилд нөлөөлөх нь





# Зохион байгуулсан арга хэмжээ

“Сумын хөгжилд  
иргэдийн оролцоо”  
нөлөөллийн ажил

Зохион  
байгуулсан  
арга хэмжээ

Хууль сурталчлах  
14 хоногийн аян

17



## “СУМЫН ХӨГЖИЛД ИРГЭДИЙН ОРОЛЦОО” НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ

Сумын ЗДТГ-тай хамтран “Сумын хөгжилд иргэдийн оролцоо” нөлөөллийн ажлын удирдамж гарган гудамж, хорооллыг албан байгууллагуудад хуваарилан өгч, тухайн байгууллагууд нь хариуцсан гудамж, хороололдоо идэхтэн ажиллууж байна. Энэ нь хууль тогтоомж сурталчлах, иргэдийн идэвхийг өрнүүлэх, төр иргэний хамтын ажиллагааг сайжруулах, иргэдийн нийгэмд хандах хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн болно.



# Хууль сурталчлах 14 хоногийн аян

Монгол Улсын хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор албан байгууллагуудын дунд хууль сурталчлах 14 хоногийн аяныг зохион байгуулсан. Хууль сурталчлах 14 хоногийн аяныг албан байгууллагууд хуваарийн дагуу 14 хоногоор ээлжлэн явуулах бөгөөд өгөгдсөн 2 хуулийг шинэлэг арга хэлбэрээр сурталчлах, иргэдийг өргөн хамруулах, явуулын сурталчилгааны /самбар, брошур, үзүүлэн гэх мэт/ материал бэлтгэж ирүүлэх, нийтийг хамарсан урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулахаар удирдамжинд заагдсан.



# Хууль сурталчлах 14 ХОНОГИЙН АЯН

Хууль сурталчлах 14 хоногийн хүрээнд ИТХ, ЗДТГ-аас “Төрийн үйлчилгээг багуудад” нээлттэй хаалганы өдрийг Мандалын Бөөрөгт үйл ажиллагаа явуулж буй “Байдрагийн хөгжил” төрийн бус байгууллага дээр зохион байгуулж, сургалт сурталчилгаа, эмнэлгийн үйлчилгээ, ИТХ, ЗДТГ-ын үйл ажиллагааны талаар санал асуулга авсан.





# ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Шилэн дансны  
тухай хуулийн  
хэрэгжилт

Сум хөгжүүлэх  
сан

Хяналт  
шалгалт

Орон нутгийн  
хөгжлийн  
сангийн  
хөрөнгөөр  
хийгдэж буй  
ажлууд

Нөхөн сэргээлтийн  
үйл ажиллагаатай  
танилцсан



# ХЯНАЛТ ШАЛГАЛТ

1

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хорооноос 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Засаг даргын Тамгын газар, Байдраг ахлах сургууль, Цэцэрлэг, Сум дундын эмнэлэг, Соёлын төвийн төсвийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг удирдамжийн дагуу шалгасан.

Төрөл	2017 оны 1-3 сар		2017 оны 4 сар		2017 оны 5 сар		2017 оны 6 сар		2017 оны 7 сар		2017 оны 8 сар		2017 оны 9 сар		2017 оны 10 сар		2017 оны 11 сар		2017 оны 12 сар		
	Төлөв	Хэмжээ	Төлөв	Хэмжээ	Төлөв	Хэмжээ	Төлөв	Хэмжээ	Төлөв	Хэмжээ	Төлөв	Хэмжээ	Төлөв	Хэмжээ	Төлөв	Хэмжээ	Төлөв	Хэмжээ	Төлөв	Хэмжээ	
1. Санхүүгийн төсвийн зардал																					
2. Санхүүгийн төсвийн орлого																					
3. Санхүүгийн төсвийн зөвлөлийн зардал																					
4. Санхүүгийн төсвийн зөвлөлийн орлого																					
5. Санхүүгийн төсвийн зөвлөлийн зөвлөлийн зардал																					
6. Санхүүгийн төсвийн зөвлөлийн зөвлөлийн орлого																					
7. Санхүүгийн төсвийн зөвлөлийн зөвлөлийн зардал																					
8. Санхүүгийн төсвийн зөвлөлийн зөвлөлийн орлого																					
9. Санхүүгийн төсвийн зөвлөлийн зөвлөлийн зардал																					
10. Санхүүгийн төсвийн зөвлөлийн зөвлөлийн орлого																					



# ХЯНАЛТ ШАЛГАЛТ

2

Орон нутгийн хөгжлийн  
сангийн гүйцэтгэлд  
хяналт тавьсан

Давсан нуурыг хаших

Хогийн цэгийн ашиглалт  
хамгаалалтад хяналт тавилаа





# ХЯНАЛТ ШАЛГАЛТ

3

Хөндлөн булаг 3 дугаар багийн нутаг Мандалын бөөрөг, Баруун салаанд үйл ажиллагаа явуулж буй Байдрагийн хөгжил төрийн бус байгууллагын гишүүд, Хувиараа ашигт малтмал олборлогч иргэд болон Жамп ХХК-ны МУ-005145 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд гэрээ байгуулан орж ирсэн Агь Хаарвист ХХК, Байдрагийн хөгжил төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид 2017 оны 10 дугаар сарын 29-ны өдөр газар дээр нь очиж танилцаж, холбогдох байгууллагуудад албан бичиг хүргүүлсэн.







# СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА

1

Төрийн албан хаагчид сургалт  
Сурагчдад сургалт, хэлэлцүүлэг

2

Бүсчилсэн сургалт

3

Багийн ИНХ-ын дарга, Тэргүүлэгчид,  
багийн Засаг дарга нарт сургалт

4

• Зөрчлийн тухай хуулийн сургалт




# СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА

1

Сумын ИТХ-аас хүсэлт явуулсны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Уранчимэгээр ахлуулсан ажлын хэсэг 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр

Төрийн албан хаагчдад сургалт  
Сурагчдад сургалт, хэлэлцүүлэг  
зохион байгуулсан





# СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА

2

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас зохион байгуулж буй бүсчилсэн сургалт 2017 оны 05 дугаар 08-ны өдөр Жаргалант суманд зохион байгуулсан. Уг сургалтанд Жаргалант, Заг, Галуут, Гурванбулаг, Баянбулаг, Хүрээмарал сумдын ИТХ-ын дарга, ИТХ-ын Нарийн бичгийн дарга нар, ЗДТГ-ын дарга нар оролцсон.





# СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА

3

ИТХ, ЗДТГ-аас Багийн ИНХ-ын дарга, Тэргүүлэгчид багийн Засаг дарга нарт 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдөр сургалт зохион байгуулсан. Сургалтын төгсгөлд сумын ИТХ-ын дарга багийн ИНХ-ын дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулсан.





# СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА

4



Сумын ИТХ-ын дарга Ж.Уранчимэг 1, 2, 3, 4 дүгээр багийн Иргэдийн Нийтийн Хуралд оролцож, 2017 оны 07 дугаар сарын 01-ээс мөрдөгдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулиар сургалт явуулсан. Сургалтанд нийт 150 гаруй хүн хамрагдсан



## ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИД, ХОРООДЫН АЖЛЫН ТАЛААР

Өлзийт өндөр 2 дугаар багаас сонгогдсон ИТХ-ын Төлөөлөгчид хөдөөгүүр тойрч, багийн иргэд сонгогчидтойгоо уулзлаа





## ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИД, ХОРООДЫН АЖЛЫН ТАЛААР

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Уранчимэгээр ахлуулсан ажлын хэсэг 2017 оны 09 дүгээр сард хөдөөгийн 1, 2, 3 дугаар багийн бүх өрхөөр тойрч, иргэдтэй уулзав. Ажлын хэсэг нь Монгол Улсын хууль тогтоомж, аймаг, сумаас гаргасан тогтоол шийдвэр, захирамжийг сурталчлах, 2017-2018 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах, отор нүүдэл хийх, өвөлжөө хаваржааны маргаантай асуудал зэрэг цаг үеийн асуудлаар багт ажиллалаа.





# ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИД, ХОРООДЫН АЖЛЫН ТАЛААР

Хэлэлцүүлэг

Сумын ИТХ-ын дэргэдэх Байгаль орчин, тохижилт үйлчилгээний хорооноос Хог хаягдлын үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэн тогтоох талаар иргэдээс санал асуулга авч, 2017.11.28 -ны өдөр Соёлын төвд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.







## БУСАД АЖЛЫН ТАЛААР

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд ажлын дэвтэр хэвлэн өгсөн.

Энэхүү дэвтэрт ИТХ-ын Төлөөлөгчийн ажлын төлөвлөлт, тойрогтоо ажилласан байдал, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, хэрхэн шийдвэрлэсэн, хуралдаан болон хурлаас зохион байгуулсан олон нийтийн ажилд оролцсон оролцоо, асуулга тавьсан эсэх зэрэг асуудлыг тухай бүр бичээд явах боломжтой юм. Мөн ИТХ-ын 2017-2020 онд баримтлан ажиллах бодлого чиглэл, ИТХ-ын Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм, ажиллах журам, ИТХ-ын 2017 оны ажлын төлөвлөгөө хэвлэн өгсөн.





## БУСАД АЖЛЫН ТАЛААР

### БАГИЙН ИНХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗӨВЛӨН ТУСЛАВ

2017 оны 05 дугаар сарын 25-26 –ны өдрүүдэд Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг дарга сонгох хуралд оролцож мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.





Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлээ.

Ойн хүрээнд иргэд, албан байгууллагуудын дунд Гар бөмбөгийн тэмцээн, Бөхийн барилдаан, “Хүүхэд-Манай ирээдүй” сайн үйлсийн аян зохион байгууллаа. ИТХ-ын 1992-2017 оны танилцуулга, тухайн онуудад хийж хэрэгжүүлсэн онцлог ажлын видео тайлан хийж танилцууллаа.



- **Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг 2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлээ.** Ойн арга хэмжээнд сум орон нутгийнхаа хөгжил дэвшилд өөрсдийн хувь нэмэрээ оруулж, ирээдүй хойч үеийнхээ сайн сайхны төлөө цуцалтгүй хөдөлмөрлөж, уйгагүй зүтгэж ирсэн үе үеийн ИТХ ын дарга, нарийн бичгийн дарга, ИТХ-ын Тэргүүлэгчид, Төлөөлөгчид ахмад буурлууд, багийн ИНХ-ын дарга, Тэргүүлэгчид, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид оролцлоо. Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойн баярын хүндэтгэлийн хурлыг ИТХ-ын дарга Ж.Уранчимэг нээж, сумын Засаг дарга Д.Сайнбилэг, ИТХ-ын Тэргүүлэгч, Төлөөлөгч Д.Ганзориг, О.Болорцэцэг нар хүндэтгэлийн индэрт үг хэллээ. Сумын ИТХ-ын 1992-2017 оны танилцуулга, тухайн онуудад хийж хэрэгжүүлсэн онцлог ажлын видео тайлан хийж танилцууллаа. Мөн баярын хурал дээр Монгол Улсын гавьяат багш, сурган хүмүүжүүлэх ухааны доктор Шархүүгийн Чимгээ “Өөрийгөө хөгжүүлэх арга ухаанд суралцахуй” сэдэвт лекц уншсан нь иргэдийн сэтгэлд нийцсэн сайхан үйл явдал боллоо. Ойн арга хэмжээний хүрээнд зарим иргэдийг шагнаж урамшуулсан.



## БУСАД АЖЛЫН ТАЛААР

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн талаар видео танилцуулга бэлтгэн албан байгууллага, иргэдийн дунд зохион байгуулдаг лекц болон багийн Иргэдийн Нийтийн Хурлын үеэр иргэдэд мэдээлэл хүргэсэн.





## Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар зөвлөл



Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн ач, зээ, төрөл төрөгсдийг 2017 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр хүлээн авч уулзан, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэд болон түүний төрөл төрөгсөд зориулан буяны ном хуруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсний зэрэгцээ үдийн зоог барьж, сумын ИТХ-аас гарын бэлэг гардуулж, хүндэтгэл үзүүллээ.





# ГХУСАЗ салбар зөвлөл

ГХУСАЗ салбар зөвлөлийн гишүүд 2017 оны 03 дугаар сарын 09-ны өдөр хуралдаж, салбар зөвлөлийн 2017 оны ажлын төлөвлөгөөг баталсан





## ГХУСАЗ салбар зөвлөл

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөө 4 бүлэг 20 заалттай бөгөөд хэрэгжилт 80 хувьтай байна.





## ГХУСАЗ салбар зөвлөл

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн “Нээлттэй өдөр” арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулж, салбар зөвлөлөөс 2017 онд хийсэн ажлын тайлан, Жаргалант суманд 2017 оны 11 сарын байдлаар гарсан гэмт хэрэг, зөрчлийн талаар иргэдэд танилцуулж, хуулийн сургалт зохион байгуулсан. Мөн 50 иргэнээс Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2018 оны төлөвлөгөөнд тусгах, цаашид хийх ажлын талаар санал асуулга авсан.



## ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал

Сумын Цагдаагийн тасгийн албан хэрэгцээнд зориулан “Бэлэн бус торгуулийн машин” /police reader/-тай болсон. Бэлэн бус торгуулийн машинтай болсноор 700,0 гаруй мянган төгрөгийн торгууль ногдуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр хүлээгдэж байна.



## ГХУСАЗ салбар зөвлөлийн зарим ажлаас дурьдвал

Сумын хөгжилд иргэдийн оролцоо” нөлөөллийн ажлын хүрээнд “Эргүүл-Хяналт” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж байна. Хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд 7 хоног бүрийн 5 дахь өдөр албан байгууллагуудын ажилчдаас Цагдаагийн тасгийн удирдлага дор эргүүлд гарган ажиллаж байна.

# ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ИРГЭД, АЛБАН БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД БОГИНО ХЭМЖЭЭНИЙ ШТОРК ХИЙХ УРАЛДААН ЗАРЛАСАН

БАТЛАВ,  
СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, /Ж/С/С – Ж УРАНЧИМЭГ

2017 оны 09 сарын 25



## ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР БОГИНО ХЭМЖЭЭНИЙ ВИДЕО СУРТАЛЧИЛГААНЫ БҮТЭЭЛ /ШТОРК/ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2017 оны 09 дүгээр сарын 19

Жаргалант

### Нэг. Үндэслэл:

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ талаар иргэд, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор богино хэмжээний видео сурталчилгааны бүтээлийн уралдаан зарлаж байна.

### Хоёр. Зорилго

- Хууль тогтоомжийг сурталчлан таниулах, иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- Уралдаанд ирүүлсэн бүтээл нь сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд үлдэх ба шалгарсан бүтээлийг цаашид сургалт сурталчилгаанд ашиглах болно.

### Гурав. Уралдааны сэдэв:

- ✓ Засаг даргын Тамгын газар -Байгаль орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
  - ✓ Байдраг ахлах сургууль - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх
  - ✓ Цэцэрлэг-Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх
  - ✓ Сум дундын эмнэлэг-Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх
  - ✓ Соёлын төв –Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх
- Иргэд дээрх сэдвүүдээс сонгон оролцож болно.
- Өгөгдсөн сэдвийн дор баримтад тулгуурласан, олны анхаарлыг татсан, гэмт хэргийг бууруулах, урьдчилсан сэргийлэх арга замыг эрэлхийлсэн байна.

### Дөрөв. Хамрах хүрээ:

Иргэд, албан байгууллагууд

### Тав. Бүтээлд тавигдах шаардлага

- Олон нийтийн цахим сүлжээ, цахим хуудас, телевизээр цацаж болохуйц богино хэмжээний видео сурталчилгааны бүтээл байна.
- Уралдааны нэр агуулгад нийцсэн, шинэлэг, сонирхолтой байх
- Бүтээл нь бусдын нэр хүнд, хувийн нууцад халдахгүй, гутаан доромжлохгүй байх
- Уралдаанд ирүүлэх бүтээл нь 2 минутаас илүүгүй хугацаатай байна.
- Бүтээлийн эхэнд "Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл үзүүлж байна" гэж үзүүлэх
- Бүтээлийн эхийг DVD –ээр ирүүлэх

### Зургаа. Хугацаа

Бүтээлийг 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба хүлээн авна.

### Долоо. Шалгаруулалтын журам

- Уралдааныг сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл шалгаруулна. /Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хүн татан оролцуулна/
- Шалгаруулалтыг 2017 оны 11 дүгээр сарын 01-ны дотор хийж, дүнг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын [jargalant.bayankhongor.khural.mn](mailto:jargalant.bayankhongor.khural.mn) цахим хуудас болон Фэйсбүүк хуудсанд байршуулна.

### Найм. Шагналын сан

1 дүгээр байр 150000 төгрөг

2 дугаар байр 100000 төгрөг

ЖАРГАЛАНТ СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛ



## Улаан загалмайн хорооны талаар

-Жаргалант сумын уугуул С.Болороо нь хүнд өвчний улмаас БНАСУ-д 40,0 сая төгрөгөөр яаралтай хагалгаанд орох болсон тул “Амьдрал бэлэглэе” сайн үйлсийн аяныг төсөвт байгууллагуудын албан хаагчид, сумын бүх иргэдэд хандан гаргасан.

-2017 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар Монголын Улаан Загалмайн хорооны татварт 2216,0 төвлөрүүлж, гэрээний биелэлт 204 хувьтай байна. Мөн 111 иргэд, малчдыг шинээр элсүүлж, бүртгэлжүүлсэн.



## ХҮҮХЭД-МАНАЙ ИРЭЭДҮЙ САЙН ҮЙЛСИЙН АЯН

“Хүүхэд-Манай ирээдүй” сайн үйлсийн аянг иргэд, албан байгууллагуудын дунд зохион байгууллаа. Аяны хүрээнд 954700 төгрөг цугларч био-00 2 ширхэг /дагалдах хэрэгсэл, суултуур/, өсгөгч 1 ширхэг, 32 инчийн телевизор 1 ширхэгийг худалдан авч, 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Цэцэрлэгийн хамт олонд сумын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид хүлээлгэн өгсөн.



Анхаарал хандуулсанд  
баярлалаа

